



Network. Partnership. Representation

"СИЛК НЭТ" ХК – ийн

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГДЭЛ

2022 оны 4-р сарын 04 өдөр

Улаанбаатар хот

"Силк Нэт" ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4-р сарын 04-ний өдрийн 11 цагт Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Худалдааны гудамж, Дельта төв 5-р давхар, 502 тоот өрөөнд эхэлсэн ба хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Хурлыг тус Хурлын дарга М.Сайнболор нээв.

-Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид та бүхэнд талархал илэрхийлье.. Та бүхэнд тооллогын комиссоос гаргасан хурлын ирцийг танилцуулъя. Компанийн нийт 374,018 ширхэг хувьцааны 90.2% буюу 337,624 ширхэг хувьцааг эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцож эхлүүлье.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах
2. Компанийн 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах
4. Их хэмжээний хэлцэл батлах тухай
5. Ногдол ашиг хувиарлахгүй тухай тайлагнах
6. Бусад.

Хурлын дэгийг танилцуулъя. Хуралаар хэлэлцэгдэх асуудлын жагсаалтын дагуу явагдана. Ингээд хурлаар хэлэлцэх эхний асуудал болох "Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан" – гийн талаар Гүйцэтгэх захирал М.Сайнболор танилцуулна.

Гүйцэтгэх захирал, хурлын дарга М.Сайнболор

Компанийн үйл ажиллагааг зогсонги байдлаас гаргах үүднээс үйл ажиллагааны үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах, гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх болон ногоон хөгжил, хиймэл оюун ухаан, финтек салбарт судалгааны ажил болон туршилтын төсөл эхлүүлсэн. 2021 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дэлгэрүүлэн авч үзвэл, дараах байдалтай байна:

Үндсэн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн. Тухайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүднээс, гүйцэтгэх удирдлагыг шинээр томилсон. Компанийн домайн нэрийг авч, шинэчлэгдсэн үйл ажиллагааны чиглэлийг үзүүлэх үйлчилгээ болгон нэвтрүүлэхээр вэбийн агуулгыг бэлтгэж байна.

Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв зэрэг газруудад байсан урьд жилүүдийн гишүүнчлэл, хувьцаа хадгалалтын төлбөрүүдийг төлж барагдуулсан.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үйл хүрээнд компанийн үйл ажиллагааны шинэ чиглэл болон стратегийг гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулах ажлууд шат дараатай зохион байгуулагдсан.

Ногоон хөгжил ESG, хиймэл оюун ухаан, мэдээлэлийн технологийн тодорхой хөрөнгө оруулалтын төслийн танилцуулга хөрөнгө оруулагчдад танилцуулсан.

Компанийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа мэргэжлийн зөвлөх үйл ажиллагааны хүрээнд эхний ээлжинд үндэсний компаниудтай хамтын ажиллагаа түншлэлийн гэрээ байгуулсан. Олон улсын байгууллагуудад Ай Ти шийдлийн зөвлөгөө өгөх, оффис ай ти үйлчилгээг үзүүлж байна.

Мөн гадны болон дотоодын компаниудад вэбэд суурилсан програм хангамж хөгжүүлэх болон мэдээлэлийн технологийн шийдлийн зөвлөгөөг өгч байна.

Финтек технологийн хүрээнд блокчэйн технологи болон криптовалютыг судалж байна. Тархмал бүтэцтэй байгууллага буюу блокчэйн бүтэцтэй холбоотой үүсэж болох өөрчлөлтийг эртнээс таниж мэдэх улмаар энэхүү өөрчлөлт компаниуд хэрхэн эрсдэлгүйгээр шилжин ороход зөвлөх үйлчилгээ үзүүлэх үүднээс этериум буюу ухаалаг гэрээний системийг судалж байна.

Бид цаашид: Ажилчдын цалин урамшуулалын системийг тодорхой болгох, Нэмэлт хөрөнгө оруулалт татах, зөвлөх үйлчилгээний платформыг хөрөнгө оруулагчидтай тохиролцсоны дагуу хөгжүүлж эхлэх, их Өгөгдөл боловсруулах чиглэлээр судалгаа хийж, бизнесийн үйлчилгээ болгон Монголд нэвтрүүлэх, бусад компанийн захиалгын дагуу вэбэд суурилсан програм хангамж, шийдэл хөгжүүлэх, нэвтрүүлэх, мэдээлэлийн технологийг нэвтрүүлэх, нутагшуулахтай холбоотой тоног төхөөрөмж, програм хангамжийн худалдаа эрхлэх, Бизнесийн удирдлага, Төслийн удирдлага, мэдээлэлийн Технологи болон Бизнес стратегитэй холбоотой мэргэжлийн зөвлөх үйлчилгээний багцтай болох, бизнесийн автоматжуулалт, өөрчлөлтийн удирдлагын чиглэлээр зөвлөгөө өгөх, ESG ногоон хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх, хамтрах, хиймэл оюун ухаанд суурилсан шинэ үйл ажиллагааг нэвтрүүлэнэ.

Хурлын дарга М.Сайнболор: Та бүхэнд асууж тодруулах зүйл байна уу. Та бүхэнд тараагдсан байгаа санхүүгийн тайлантай танилцаад асуух зүйл байвал асуугаарай. Хувьцаа эзэмшигчид: Байхгүй ээ. Цаашид хэрэгжүүлэх төсөл төлөвлөгөөг бүрэн дэмжиж байна.

Хурлын дарга М.Сайнболор: Компани ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн болно. Компанийн дүрэмд: Компанийн албан ёсны хаягийг Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж, Pearl Tower 1101 тоот өрөө болгон өөрчилөх мөн компанийн оноосон нэрийг өөрчилөх саналтай байна. Компаний үйл ажиллагааны чиглэлд бизнесийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ, ESG advisory Environmental, Social, and Governance/, хиймэл оюун ухааны зөвлөх үйлчилгээ, мэдээлэлийн технологийн үйлчилгээг нэмж авхаар санал оруулж байна.

Их хэмжээний хэлцэл батлах асуудал байгаа. Гэхдээ энэ хэлцэл хийгдэх эсэх нь тодорхой бус байгаа. Яг хэлцэл хийх болход хурал зарлах гээд хугацаа их алддаг, гэрээ хэлцэл маань хойшлогдох магадлалтай тул санал солилцож байгаа асуудлын хүрээнд уг асуудлыг хэлэлцүүлэхээр санал авч байна. Компани цаашид ногоон хөгжил, хиймэл оюун ухаан, мэдээлэлийн технологи программ хангамжид суурилсан бизнес явуулахаар төлөвлөж байгаа тул гадны хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулалтын сангаас хоёр тэрбум төрөг хүртлэх зээлийг одоогийн банкны зээлийн хүүнээс хэтрүүлэлгүйгээр авах төлөвлөгөөтэй байна. Мөн одоо хамгийн хэцүү асуудал болох хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх үүднээс өргөн цар хүрээгээр үйл ажиллагаа явуулах гэж байгаатай холбогдуулан мэдлэг чадвартай мэргэшсэн

боловсон хүчин, компанитай олон жилийн хугацаатай ажиллахаар хэлцэл байгуулах нь тогтвортой нэж үзэж энэ асуудлыг оруулж ирлээ.

Хурлын дарга М.Сайнболор: – Та бүхэнд хурлаар хэлэлцэгдсэн асуудлаас гадна хэлэх санал, хүсэлт байна уу?

Хуралд оролцогчид – Нэмж хэлэх зүйл алгаа.

Хурлын дарга М.Сайнболор: За тэгвэл бидний өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудал дуусч байна. Ингээд санал хураалтаа эхлүүлэе.

Хувьцаа эзэмшигчдээс өөр санал, асуулт гараагүй тул санал хураалтыг эхлэв.

Саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсөний дараа хурлын дарга Хувьцаа эзэмшигчдэд хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга танилцуулав.

Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож, нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна. Хүчингүй саналын хуудас гараагүй.

Хурлын дарга М.Сайнболор:– Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсье. Баярлалаа.

“Силк Нэт” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 12.20 цагт дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:

Ц.Сарантуяа

Хянасан: Хурлын дарга

М.Сайнболор

